БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2016

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНД СУРТАЛ АВИЛГА ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....2

Товч танилцуулга.....6

Үндсэн үзүүлэлтүүд..... 15

I. 1 Хүн ам.....16

I. 2 Хөдөлмөр.....17

I. 2 Нийгмийн даатгал.....18

I. 3 Эрүүл мэнд 18

I. 4 Гэмт хэрэг 19

II.2 Үнэ.....21

II.4 Аж үйлдвэр.....23

II.8 Хөдөө аж ахуй.....24

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

-Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
-Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
-Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
-Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
-Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
-Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
-Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
-Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
-Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томьёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^{n} p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^{n} p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - ‘i’ барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - ‘i’ барааны суурь үеийн үнэ,

q_{io} - ‘i’ барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$ - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I.Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I,II,III,IV,V….гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмгдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

\- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I.Нийгмийн үзүүлэлт

I.1 Хүн ам

2016 оны жилийн эцсийн урдчилсан дүнгээр Булган аймгийн хүн ам 61149 болсон нь өмнөх оноос 1135 хүн буюу 1.9 хувиар өссөн байна. Үүнээс эрэгтэйчүүдийн тоо 31077 болж өмнөх оны мөн үеэс 565 буюу 1.9 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 570 буюу 1.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг I.1.1

Хүн ам



2016 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 1275 хүүхэд, нас барсан 405 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 7.7 хувиар буурч, нас баралт 14.1 хувиар өсчээ.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



Жилийн эцсийн байдлаар 1321 хүн шилжин ирж, 1662 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 249 буюу 23.2 хувиар өссөн бол, шилжин явсан хүн 138 буюу 7.6 хувиар буурсан байна.

Зураг I.1.3

Шилжих хөдөлгөөн

I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны жилийн эцэст 1456 болсны 709 нь эмэгтэйчүүд байна. Өмнөх оны мөн үеийнхээс ажил хайгч иргэн 958 хүн буюу 2.9 дахин хувь өссөн байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэн 1066 болсны 523 эмэгтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал 624 хүн буюу 2.4 дахин хувь өссөн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.18 хувийг магистр болон докторын зэрэгтэй, 17.7 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.93 хувийг тусгай мэргэжлийн дунд, 5.06 хувийг техникийн болон мэргэжлийн, 53.8 хувийг бүрэн дунд боловсролтой, 14.6 хувийг суурь боловсролтой, 3.84 хувийг бага боловсролтой, 0.75 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 13.2 хувийг 15-24 насны, 34.2 хувийг 25-34 насны, 25.8 хувийг 35-44 насны, 19.04 хувийг 45-54 насны, 5.06 хувийг 55-59 насны, 2.53 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр

I 3. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны жилийн эцсийн байдлаар 11998.5 сая төгрөг, зарлага 31482.7 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 1539.9 сая төг буюу 14.7 хувиар өсч, зарлага 1650.4 сая төг буюу 5.5 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 1539.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэмжийн даатгалын сангийн орлого 56.9 сая.төг буюу 7.4 хувиар, тэтгэврийн даагалын сангийн орлого 460.5 сая.төг буюу 6.8 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 957.6 сая.төг буюу 43.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 1650.4 сая.төг буюу 5.5 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сан 2006 сая.төг буюу 7.8 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 105.3 сая.төг буюу 43.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин тэтгэмжийн даатгалын сан 80.7 сая.төг буюу 7.1 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 79.2 сая.төг буюу 3.4 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 301 сая.төг буюу 55.6 хувиар тус тус буурсан байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны жилийн эцсийн байдлаар 12899 хүн 4808.9 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 1124.2 сая.төг буюу 30.5 хувиар өсчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1394 хүн хамрагдаж 1776.3 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 78.9 сая.төг буюу 4.6 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2016 оны жилийн эцсийн байдлаар 7485 хүн хамрагдсаны 30.6 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 21.8 хувь ахмад настан, 5.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0.7 хувь нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, 41.6 хувь нь хүнс тэжээл хөтөлбөрт хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 1445.8 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 777.3 сая.төг буюу 116.3 хувиар өссөн байна.

I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 868 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 871 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 117 буюу 11.8 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 120 буюу 12.1 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.4.1

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 3 жилийн байдлаар



1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 14, 0-ээс 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 12 болж өмнөх оны мөн үеийнхээс 5 тохиолдол буюу 29.4 хувиар буурсан байна.

Нялхасын эндэгдэл 2016 оны жилийн эцэст 12 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5 буюу 29.4 хувиар буурсан байна.

Зураг I.4.2

Эндсэн хүүхэд, сүүлийн 3 жилийн байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2016 оны жилийн эцсийн байдлаар 753 болж, өмнөх оны мөн үеийнхээс 404 тохиолдол буюу 2.1 дахин өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 518 буюу 68.7 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 188 буюу 24.9 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 3 жилийн байдлаар

I.5. Байгаль орчин

Цаг уурын урьдчилсан мэдээ

2017 оны 1 дүгээр сарын урьдчилсан төлөв: Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нутгийн баруун хэсгээр 18-23 градус, бусад нутгаар 11-17 градус хүйтэн байдаг.

Энэ сард нутгийн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх.

Уур амьсгалын дунджаар нутгийн хойд хэсгээр 2-3мм, бусад нутгаар 2мм хүртэл цас ордог.

Энэ сард нийт нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй

1-р сарын 02-ноос 09-ныг хүртэлх цаг агаарын тойм

Тунадас: 8-нд Ингэттолгой, Хангалд 0.4-0.6 мм цас орсон. Бусад нутгаар цас ороогүй байна.

Цасны зузаан: Өнөө өглөөний байдлаар цаг уурын талбай дээрх хэмжилтээр Хангал 23 см, Тэшиг 20 см, Бугат 18см, Булган 15см, Орхон 13см, Баян-Агт, Сэлэнгэ, Хутаг-Өндөр 12 см, Баяннуур 9 см, Рашаант 8 см, Гурванбулаг 7 см, Сайхан 5 см, Дашинчилэн 4 см, Могод, Бүрэгхангай 3 см, Хишиг-Өндөр 2 см цас тус тус орсон байна.

Салхи: Ихэнх хугацаанд 0-9м/с, 8-аас 9-нд шилжих шөнөдөө Могодод түр зуур 14м/с хүрч явган шуурга шуурсан байна.

Температур: Томоохон голын хөндийгөөр шөнөдөө 28-34 градус, өдөртөө 18-24 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 12-27 градус, өдөртөө 2-16 градус хүйтэн байлаа.

Энэ 7 хоногийн цаг агаарын урьдчилсан төлөв (1-р сарын 9-нөөс 16-ныг хүртэлх)

Тунадас: 11-нээс 12-нд шилжих шөнөдөө нутгийн зүүн хойд хэсгээр 15-нд зарим газраар бага зэргийн цас орно.

Салхи: Ихэнх хугацаанд 5-10м/с, 12-нд зарим газраар 12-14м/с хүрч явган шуурга шуурна.

Температур: Томоохон голын хөндийгөөр шөнөдөө 28-33 градус өдөртөө 18-23 градус хүйтэн бусад нутгаар шөнөдөө 20-25 градус өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2016 оны жилийн эцсийн байдлаар 68 удаа гарч, 7 хүн амь насаа алдаж, 40.1 мян. толгой мал, амьтан хорогджээ. Мөн гэр, авто машин, объектын түймэр 24 удаа гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад объектын түймэр 33.3 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд 2418.4 сая.төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 674.3 сая.төгрөг буюу 21.8 хувиар буурсан байна.

Хорогдсон, устгасан мал тэжээвэр амьтад өмнөх оны мөн үеийнхээс 10.1 мян толгой буюу 20.4 хувиар буурсан байна.

Зураг I.2.1

Аюулт үзэгдэл, осол болон объектын гал түймрийн тоо, оноор



Жилийн эцсийн байдлаар аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо өмнөх оны мөн үеийнхээс 47.7 хувиар, объектын түймэр 33.3 хувиар буурсан байна.

Ойжуулалт нөхөн сэргээлт

Аймгийн хэмжээнд ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15 га, ойжуулалтын ажлыг 171.4 га, ногоон байгууламжийн 1.9 га, нийт 467.5 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлт, мод тарих бүх нийтийн хөдөлгөөний хүрээнд 31339 ширхэг мод тарих ажлыг хийж, 350 иргэнийг түр ажлын байраар хангасан.

Ойн ашиглалт 2016 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний зориулалтаар 7181.3 мян.м³, түлээний зориулалтаар 48923.5 мян. м³, нийт 56104.8 мян.м³ модыг 2230.2 га талбайгаас бэлтгэсэн байна.

Ойн санд учирсан хохирол Аймгийн хэмжээнд 6 ойн түймэр гарч, 6.1 мян.га талбай түймэрт нэрвэгдэж, ойжуулалтын арга хэмжээнд 251375.0 мян.төгрөг зарцуулсан байна.

Цэвэр ус Амгийн хнэмжээнд гадаргын усны нөөцийн хэмжээ 9604 сая.м³, газар доорхи усны нөөцийн хэмжээ 313.5 сая.м³, хамгаалалтад авсан 47 усны эх үүсвэр байна. Гадаргын усны сэргэсэн эх үүсвэр гол горхи 24, булаг шанд 91, нуур цөөрөм 17, нийт 132 байгаа бол ширгэсэн эх үүсвэр 95 байна.

I.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 32 хэргээр буюу 10.7 хувиар буурсан байна. БҮСТЗЭТХэрэг 117 бүртгэгдэн 74 хэргийг илрүүлэлт 63.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.3 хувиар өссөн байна.

Зураг I.6.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг , жилийн эцсийн байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл

- ИЭЧЭМЭГХ 92 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 11 хэргээр буюу 10.6 хувиар
- ХАБАЖЭГХ 26 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 10 хэргээр буюу 26.3 хувиар
- Танхайрах гэмт хэрэг 2 бүртгэгдэж 5 хэргээр буюу 2.5 хувиар
- Бусдын амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнө оны мөн үетэй харьцуулахад 50 хувиар
- Дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 2 дахин
- БХЖЭГХ 5 бүртгэгдэн урьд оны мөн үеэс 6 хэргээр буюу 1.2 дахин
- БХЖЭГХ 5 бүртгэгдэн урьд оны мөн үеэс 6 хэргээр буюу 1.2 дахин буурсан байна.
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 7 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 42.8 хувиар
- Хулгайн гэмт хэрэг 101 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 2.9 хувиар өсч, үүнээс мал хулгайлах хэрэг 39 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 9 хэргээр буюу 23 хувиар буурчээ.
- Хүчиндэх гэмт хэрэг 10 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 50 хувиар
- Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн урьд оны мөн үеэс 50 хувиар
- Золгүй байдлаар амь насаа алдсан хэрэг 6 бүртгэгдэж 33.3 тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас нийт иргэд , аж ахуй нэгж байгууллагад 759.8 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 679.0 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 555.0 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан .

Зураг I.6.2

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жилийн эцсийн байдлаар



Гэмт хэргийн улмаас 29 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 20.8 хувиар өссөн байна. Хэргийн өнгөөр нь авч үзвэл ХАБАЖЭГХ-н улмаас 15 хүн, хүн амины хэргийн улмаас 7, болгоомжгүй хүн амь

насыг хохироох гэмт хэргийн улмаас 1, золгүй байдлаар 6 хүн нас барсан байна. Гэмт хэргийн улмаас 294 иргэн хохирсноос 124 иргэн гэмтсэн байна. ИЭЧЭМЭГ хэргийн улмаас 97, хүчиндэх гэмт хэргийн улмаас 2, танхайрах гэмт хэргийн улмаас 2, ХАБАЖЭГ хэргийн улмаас 21, бусад хэргийн улмаас 4 хүн гэмтсэн байна.

Зураг I.6.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жилийн эцсийн байдлаар



2016 оны жилийн эцсийн байдлаар гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 567 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 1.2 хувиар өссөн бол, захиргааны журмаар 43 хүнийг баривчилж шийтгэл эдлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 138 хүнээр буюу 75.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна . Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 303 иргэн байна

Шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээ

2016 оны жилийн эцсийн байдлаар Шүүхийн шинжилгээний үзлэгээр нийт 689 шинжилгээ хийгдсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 117 шинжилгээ буюу 20.4 хувиар өссөн байна. Нийт хийгдсэн шинжилгээг төрлөөр авч үзвэл криминалистикийн шинжилгээ 58, шүүх эмнэлэгийн шинжилгээ 89, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 385, химийн шинжилгээ 157 хийгджээ.

Зураг I.6.4

Криминалистик шинжхилгээ, Шүүх эмнэлэгийн шинжилгээ эхний хагас жилийн байдлаар



КШ-Криминалистикийн шинжилгээ
ШЭШ-Шүүх эмнэлэгийн шинжилгээ
ГЗТҮ-Гэмтлийн зэрэг тогтоох үзлэг
ХШ-Химийн шинжилгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны мэдээ

2016 оны жилийн эцсийн байдлаар 314 шийдвэрийн 1376.5 сая төгрөгийн шийдвэр гүйцэтгэхээс 239 хэргийн 707.0 сая төгрөгийн шийдвэрийг гүйцэтгэж ажилласан байна. Шийдвэр гүйцэтгэлийн биелэлт 49.1 хувьтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн иргэний хэргийн шийдвэртэй 198, эрүүгийн хэргийн шийдвэртэй 34, захиргааны хэргийн шийдвэртэй 7, бусад хэргийн шийдвэр энэ оны эхний хагас жилд байхгүй байна

II.Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв

Орон нутгийн төсвийн нийт орлого 2016 оны жилийн эцсээр 50354.6 сая төгрөг, зарлага 50425.9 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 71.3 сая төгрөгний сөрөг гарлаа.

Зураг II.1.1

Аймгийн төсвийн орлого, зарлага жилийн эцсийн байдлаар, сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 17844.9 сая. төг буюу 35.4 хувийг татварын орлого, 31847.5 сая.төг буюу 63.2 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны жилийн эцсийн байдлаар 50425.9 сая.төг болоход 69 хувь буюу 34918.1 сая.төг

бараа материалын зардал, 12.6 хувь буюу 6394.9 сая.төг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт авлага 54,1 сая, өглөг 128,8 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 41,7 сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 52,8 сая, эмийн өр 5,4 сая, албан томилолт 17,3 сая, бусад зардлын өглөг 11,6 сая төгрөг байна.

II.2 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2015 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.2 хувиар өссөн, оны эхнээс 1.2 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 хувиар өслөө.

Зураг II.2.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)



Хүснэгт II.2.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 X 2015 X	2016 X 2015 XII	2016 X 2016 IX
Ерөнхий индекс	99.8	100.8	99.8
Хүнсний бараа, ундаа, ус	98.4	102.7	98.0
Согтууруулах ундаа, тамхи	99.0	98.8	100.1
Хувцас, бөс, бараа, гутал	99.3	100.2	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.7	102.0	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	97.7	98.8	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Тээвэр	101.5	101.5	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.5	99.6	100.3
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.4	99.3	101.1

Зураг II.2.2

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2015 оны I-X, 2016 оны I-X сар, (өмнөх сар=100%)



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт жилийн эцсийн байдлаар 6138.8 сая.төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1899.1 сая.төгрөг буюу 23.6 хувиар буурсан байна .

Зураг II.2.2

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт жил бүрийн 12 сарын байдлаар

Аж үйлдвэрийн салбар нь жилийн эцсийн байдлаар 8095.5 сая төгрөгний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4929.5 сая.төг буюу 37.8 хувиар буурсан байна.

Худалдан авах ажиллагаа

Аймгийн худалдан авах ажиллагааны алба нь 2016 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвөөс 2 төсөл арга хэмжээ буюу 100.0 сая.төг, орон нутгийн хөгжлийн сангаас 11 төсөл арга хэмжээ буюу 1024.8 сая.төгрөг, авто замын сангаас 2 төсөл арга хэмжээ буюу 42 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 22 төсөл арга хэмжээ буюу 2557.1 сая.төгрөг, нийт 37 төсөл арга хэмжээ буюу 3723.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал төсөл арга хэмжээний тоо 13.9 хувиар, батлагдсан төсөвт өртөг 52.1 хувиар тус тус буурсан байна. Нийт төлөвлөгөөт 37 төсөл арга хэмжээнээс 37 төсөл арга хэмжээ буюу 3723.9 сая төгрөгийн тендер зохион байгуулснаас 34 төсөл арга хэмжээний гэрээг байгуулж, төлөвлөгөөний биелэлт 100 хувь

Өмчийн алба

2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 21 удаагийн тогтоолоор орон нутгийн өмчит сум, байгууллагын 496.9 сая.төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 7 нэгж, байгууллагын 11 тээврийн хэрэгслийг 19.3 сая.төгрөгөөр худалдан борлуулах шийдвэр гаргуулж, 5 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулж хөрөнгө борлуулсны орлогыг орон нутгийн төсөвт 7.6 сая.төгрөг, орон нутгийн өмчийн барилга байгууламжийн төрийн болон хувийн хэвшлийн 5 байгууллагад түрээслэн 13.5 сая.төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журмын хэрэгжилтийн хүрээнд 21 удаагийн тогтоолоор 399.6 сая.төгрөгийг хөрөнгийг актлах, 74.1 сая.төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх, 19.3 сая.төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гаргуулсан байна.

II.8 Хөдөө аж ахуй

Малын тоо

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2016 оны жилийн эцэст манай аймаг мал сүргийн нийт дүн 3485.6 мянган толгойд хүрч, 2015 оныхоос 1.7 хувь буюу 55.5 мянгаар өслөө. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо толгой 268.7 мянга, үхэр 284.9 мянга, тэмээ 1.3 мянга, хонь 1827.7 мянга, ямаа 1034.7 мянга хүрч, 2015 оныхоос адуу 4.5 мянга буюу 1.6 хувиар, үхэр 3.4 мянга буюу 1.2 хувиар, 129.9 мянга хонь буюу 7.6 хувиар, ямаа 55.8 мянган толгой буюу 5.7 хувиар, тэмээ 85 толгой буюу 1.2 хувиар тус тус өссөн байна. Улсын хэмжээнд 2016 онд тоологдсон 61542.0 мянган толгой мал тоологдсоны 5.6 хувийг манай аймгийн мал эзэлж байна. 2016 онд нийт мал сүргийн тоогоороо улсын хэмжээнд 8-р байрт байна. Нийт мал сүргийг 5 төрлөөр нь аймагтай харьцуулвал адуун сүргийн тоогоороо 6-р байр, үхэр сүргийн тоогоороо 4-р байр, хонин сүргийн тоогоороо 6-р байр, ямаан сүргийн тоогоороо 13-р байр, тэмээн сүргийн тоогоороо 16-р байранд, нийт мал сүргийн тоогоор Бүрэгхангай сумын 3-р баг 4-р байранд, адуун сүргийн тоогоор Сайхан сум 3-р байр, хонины сүргийн тоогоор Бүрэгхангай сумын 3-р баг 4-р байранд тус тус орж байна.

Нийт мал сүргийн дотор адуу 7.9 хувь, үхэр 8.4 хувь, тэмээ 0.04 хувь, хонь 53.4 хувь, ямаа 30.3 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 0.1 пункт, адуу 0.3 пункт, үхэр 0.3 пунктээр тус тус буурч, хонь 0.7 пунктээр өсч, тэмээний эзлэх хувьд өөрчлөлт орсонгүй.

Зураг II.8.1

Малын тоо толгой сумаар 2016 оны жилийн эцсийн байдлаар

Малчин өрх

Аймгийн хэмжээнд 2016 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 10595 өрх тоологдсон байна. Үүний 78.3 хувь буюу 8301 малчин өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг ба 21.6 хувь буюу 2294 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна. 2016 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 15579 малчид ажиллаж байна. Малчдын 45.5 хувь нь буюу 7103 нь эмэгтэй малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 27.4 хувь нь 15-34 насны, 61.7 хувь нь 35-59 насны, 10.9 хувь нь 60-с дээш насны хүмүүс байна.

Зураг II.8.2

Малтай өрх, малчин өрх



Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2016 оны жилийн эцсийн байдлаар 58.2 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 14.2 мян. толгой мал буюу 19.7 хувиар буурсан байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 5.2 мянга буюу 9 хувь, үхэр 6.8 мянга буюу 11.8 хувь, хонь 26.6 мянга буюу 45.7 хувь, ямаа 19.5 мянга буюу 33.5 хувь буюу оны эхний малын 2 хувь нь тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 79.2 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Баяннуур сум 19.5 хувь, Рашаант сум 18.2 хувь, Гурванбулаг сум 14.2 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Өвчнөөр хорогдсон мал 3.1 мян.толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 9 толгой мал буюу 0.2 хувиар буурсан байна.

Зураг II.8.3

Том малын зүй бусын хорогдол, 2016 оны жилийн эцсийн байдлаар



Зураг II.8.4

Малын тоо толгой сумаар 2016 оны жилийн эцсийн байдлаар

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны 12 сарын байдлаар адууны шир 35.0 мян.төгрөг,

үхрийн 1.8-2.3 м урттай шир 20.0 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 35.0 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 20.4 хувиар, үхрийн 2.3 метрийн урттай шир 9 хувиар буурсан, ямааны арьс 1 дахин, адууны дэл 15.4 хувиар, адууны сүүл 33.2 хувиар, хонины нэхий 26.6 хувиар тус тус өссөн байна.

Малын дундаж үнэ: 2016 оны жилийн эцсийн байдлаар тэмээ 900 мян.төг, адуу 615 мян.төг, үхэр 818 мян.төг, хонь 108 мян.төг, ямаа 80 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 10.3 хувиар, адуу 0.7 хувиар, үхэр 0.9 хувиар, хонь 8 хувиар, ямаа 1.9 хувиар тус тус буурчээ.

2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 42125.8 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 37651.8 га, төмс 518.5 га, хүнсний ногоо 262.9 га, техникийн ургамал 2731 га, тэжээлийн ургамал 405.6 га, эмийн ургамал 556 га талбайд тус тус тариалсан байна.

Өнгөрсөн мөн үетэй харьцуулахад нийт тариалсан талбай 2.4 хувиар буюу 1005.5 га-гаар өссөн. Үүнээс: үр тариа 61.6 га буюу 16 хувиар, хүнсний ногоо 6 га буюу 2.2 хувиар буурсан ба техникийн ургамал 449 га буюу 19.7 хувиар, төмс 21.5 га буюу 4.3 хувиар, тэжээлийн ургамал 46.6 га буюу 13 хувиар өсч, эмийн ургамал 550 га-д нэмж тариалсан байна.

Зураг II.8.5

Тариалсан талбай, төрлөөр, оноор, га



2016 оны байдлаар аймгийн хэмжээнд 798 өрх, 106 аж ахуй нэгж байгууллага тариалалт хийсэн байна.

Зураг II.8.3

Тариалсан талбай, өрхөөр, га



Зураг II.8.6

Тариалсан талбай, аж ахуй нэгжээр,га

Хураасан ургац

2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 42106.8 га талбайгаас 62512.9 тн ургац хураасан байна. Үүнээс: үр тариа 53.7 мянга тн, төмс 4.9 мянга тн, хүнсний ногоо 1.7 мянга тн, тэжээлийн ургамал 0.5 мянга тн, 1.5 мянга тн техникийн ургамал тус тус хураан авсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үр тариа 85.4 хувиар, техникийн ургамал 2 дахин, тэжээлийн ургамал 57.7 хувиар өсч, төмс 2.6 хувиар, хүнсний ногоо 18.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд байгалийн хадлан 101.7 мянга тн, гар тэжээл 2.3 мянган тн, хужир шүү 4.9 мянган тн бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийхээс хадлан 17.5 хувиар, гар тэжээл 12.6 хувиар, хужир шүү 47.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг II.8.7

Хураасан ургац, төрлөөр, тн



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

